



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ТОГТООЛ

2023 оны 07 сарын 05 өдөр

Дугаар 267

Улаанбаатар хот

Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл
ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл
олгох тухай

Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7.1.2, 11 дүгээр зүйлийн 11.2, 11.3, 11.4 дэх хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 8 дахь хэсгийн 8.2 дахь заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн чиглэлээр "Инфинити спейс" ХХК-д Дорноговь аймгийн Алтанширээ, Өргөн сумын нутаг дэвсгэрт "Алтанширээт" үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх, "Си Өү Эй Эл" ХХК-д Дорноговь аймгийн Хөвсгөл сумын нутаг дэвсгэрт "Гэрэлт говь" үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг тус тус 15 (арван таван) жилийн хугацаатайгаар олгосугай.

2. Энэ тогтоолын 1-д заасан тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй холбогдох хуулийн дагуу гэрээ байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

УУЛ УУРХАЙ, ХҮНД
ҮЙЛДВЭРИЙН САЙД

Ж.ГАНБААТАР